

БАГШИЙН МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАРЫГ ДЭС ДАРААТАЙ, ЦЭГЦТЭЙ ДЭЭШЛҮҮЛЭХ АСУУДАЛД

Д.Оюунсүрэн
АШУҮИС, Дархан-Уул АУС
oyunsuren.dn@mnums.edu.mn

Хураангуй

Боловсрол судлалын талаас авч үзвэл тодорхой салбар шинжлэх ухааны мэдлэгийг зааж сургахын тулд эхлээд тухайн салбараар мэргэшсэн байх нь чухал. Өөрөөр хэлбэл анагаахын мэргэжлийн багш нар сайн эмч нар багшийн хөгжлийн үндсэн зорилго юм.

Багшийн хөгжлийн үйл ажиллагааны үндсэн хэсэг нь хичээл заах, сургалтын баримт бичиг (хөтөлбөр, стандарт, удирдамж г.м) боловсруулах, сургалтын чиглэлээр судалгаа хийх, сургалтын төлөвлөлт, зохион байгуулалтад оролцох, мэргэжлийн үйл ажиллагаанд оролцох явдал.

Анагаахын багшийн мэргэжлийн хөгжлийн нэг чухал, салшгүй хэсэг нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд идэвхтэй оролцох нь тэднийг мэргэжлийн салбартаа тэргүүлэгч байх нэг үндсэн нөхцөл нь болдог аж.

Анагаах ухааны боловсрол өндөр хөгжсөн орны туршлагаас харахад багшийг хөгжүүлэх хөтөлбөр нь анагаахын сургуульд, үндэсний нийгэмлэг холбоонд, олон улсын байгууллагад суурилан явагдаж байна.

Түлхүүр үг: Багшлахуйн чанар, багшийн ур чадвар, сургалтын арга барил, сургалтын онцлог

Үндэслэл:

Анагаахын багшийн хөгжил гэдэг нь тэдний сурган заах арга зүйн, манлайлах, өөрийгөө хөгжүүлэх, ур чадварыг эзэмшүүлэх цэгцтэй үйл явц юм.

Эрдэмтэн судлаач нар багшийг хөгжүүлэх хөтөлбөр нь

1. Багшийн мэргэжлийн онцлогыг таниулах / шинэ багш нарт сургалтын байгууллага, тэнд ажиллагсдын үүргийг ойлгуулах/
2. Заах арга зүйг хөгжүүлэх /бүх багш нар боловсрол судлалын талаарх сургалт семинарт оролцох, хамт ажиллагсдаас хариу мэдээлэл авах, зөвлөгөө авах боломжтой байх /
3. Манлайлах ур чадварыг дээшлүүлэх / сургалтын хөтөлбөр манлайлагчид болон сайн төлөвлөгдсөн сургалтын төлөвлөгөөнөөс хамааралтай, тэдгээр манлайлагчид нь суралцагчдын анагаах ухааны боловсрол олгох сургалтыг үнэлэх, дээшлүүлэх ур чадварыг хөгжүүлдэг/
4. Байгууллагыг хөгжүүлэх /сурган хүмүүжүүлэгчид гэдэг утгаар нь багш нарын багшлах болон тасралтгүй суралцах үйл ажиллагааг урамшуулах, хөхүүлэн дэмжих бодлого, үйл ажиллагааг боловсронгуй болгох/ зэрэгт үндэслэсэн байх нь зүйтэй гэж дурджээ.

Мэргэжлийн сургуулиудын багшлах боловсон хүчний нэг онцлог нь багш хэмээх мэргэжлийг үндсэн мэргэжилтэйгээ давхар эзэмшдэгт оршдог. Эрдэмтэн зохиолч Л.Түдэв гуай нэгэнтээ анагаахын багш нар хоёр хөлтэй нэг нь эмч, нөгөө нь багш юм гэж хэлсэн байдаг. Орчин үеийн шинжлэх ухаан, мэдээллийг дамжуулах технологийн үсрэнгүй хөгжил, зах зээлийн өрсөлдөөн нь аливаа мэргэжлийн салбарт ажиллаж буй мэргэжилтнүүдэд өөрийгөө байнга хөгжүүлэх хэрэгцээг бий болгож байна. Өнөөдөр анагаах ухааны боловсролын салбарт ажиллаж буй эмч багш нарт мэргэжлийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэхээс гадна, сурган заах арга зүйн мэдлэг ур чадварыг дээшлүүлэх асуудал маш чухлаар тавигдаж байна. Ийм учраас энэхүү сэдвийг сонгон судалсан болно.

Зорилго: Анагаахын багшийн мэргэжлийн ур чадварыг дэс дараатай, цэгцтэй дээшлүүлэх асуудлыг судлах.

Зорилт:

Анагаахын багшийн хөгжилд нөлөөлдөг суурь 10 үзүүлэлтээс 4 дэх үзүүлэлт болох ур чадварыг дэс дараатай, цэгцтэй дээшлүүлэх асуудлыг онолын түвшинд судлах.

Материал, арга зүй:

Анагаах ухааны боловсрол өндөр хөгжсөн орны туршлага, Ази номхон далайн бүсийн болон дэлхийн хэмжээний хурал чуулганы мэдээ, судалгааны үр дүн болон туршлага, өөрийн орны анагаахын сургуулиудын туршлага зэргээс уншиж, судалгааны боловсруулалтыг хийлээ.

Үр дүн:

Ази Номхон Далайн Нийгмийн Эрүүл Мэндийн Консерциумын жил тутмын хурлын нэг чухал хэсэг нь анагаах ухааны боловсрол бөгөөд энэ чиглэлээр хийгдсэн сургалтын үр дүнг жил бүр хэлэлцдэг. Д.Цэрэндагва, Ц.Лхагвасүрэн, Д.Дүнгэрдорж нарын судалгаагаар Азийн анагаах ухааны сургуулиудын 90% нь багш хөгжүүлэх тусгай програмтай бөгөөд энэ чиглэлээр ДЭМБ, АНУ дахь Гадаадын эмч нарын боловсролын холбоо (ECFMG), Шотландын Данди их сургууль дахь Анагаахын боловсролын төв, Австралийн Шинэ Өмнөд Уэльсийн Их сургууль зэрэг байгууллагуудтай хамтран ажилладаг байна.

Д.Отгонбаяр, Д.Цэрэндагва, Н.Сүмбэрзул нарын судалгаагаар багшийг хөгжүүлэх шаардлагатай байгааг тэд дурьдсан.

Багшийг хөгжүүлэх нь дараах зүйлд суурилна. Үүнд:

1. Удирдлагын хүчтэй дэмжлэг
2. Багш хөгжүүлэх хөтөлбөрт оролцогчдыг дэмжих тогтолцоо
3. Багшлах нь их сургуулийн багшийн үндсэн үүрэг
4. Ур чадварыг дэс дараатай, цэгцтэй дээшлүүлэх
5. Насанд хүрэгчдийн сургалтын зарчимд суурилах
6. Хэрэгцээг соргог мэдрэх
7. Оролцогчид бие биеийнхээ туршлагаас суралцах
8. Бие биедээ итгэсэн, дэмжсэн уур амьсгалыг бүрдүүлэх
9. Хамтын ажиллагаа, багаар ажиллах, нэгдсэн зорилгод тулгуурлах
10. Амжилтыг тухай бүр нь хөхүүлэн дэмжих

Багшийг хөгжүүлэх үйл ажиллагаанд хэрэглэгддэг үндсэн хэсгүүдийг анагаахын боловсрол олгодог байгууллагууд өргөн хэрэглэж байна.

Шинээр ирсэн багшийг туршлагатай багшид дагалдуулан хичээлд суулгаж улмаар хичээл заалгуулдаг, ахмад багшийг залуу багшийн халамжлан хүмүүжүүлэгчээр ажиллуулдаг туршлага бий.

Багшийг хөгжүүлэх хөтөлбөрийг багууллагын дэмжлэг, эрхэм зорилго, зорилтууд, нөөц болон хувь хүний хэрэгцээнээс салангад авч үзэх боломжгүй юм.

Анагаах Ухааны Боловсрол судлалын салбарт сүүлийн жилүүдэд сургалтын өөрчлөлтөнд багшийн гүйцэтгэх үүргийг өөрчлөх явдал чухлаар тавигдаж байна.

Дэлхийн Анагаах Ухааны Боловсролын холбооны тэргүүн Ronald Harden-ийн судалж тогтоосноор Анагаахын сургалтанд 6 хүрээнд багтаасан багшийн 12 үүргийг тодорхойлсон загвар байдаг. Үүнд:

1. Information provider- мэдээлэл түгээгч
2. Role model- үлгэрлэн дуурайлагч
3. Facilitator- чиглүүлэгч
4. Assessor- үнэлэгч
5. Planner- төлөвлөгч
6. Resource developer- нөөцийг хөгжүүлэгч

Дээрх модель нь багш нар хоорондоо “өрсөлдөөнт чанарыг” буй болгоно.

Сайн багш гэдэг нь оюутнуудад суралцахад тусалдаг, чиглүүлэгч багшийг хэлнэ. Багш төвтэй сургалтанд багш нь мэдээллийг дамжуулагч, оюутан төвтэй сургалтанд багш нь оюутнуудын амжилтанд хүрэх арга зам, идэвхийг өрнүүлэгч, оюутнуудад сурах эрмэлзлэл- мотиваци төрүүлэгч байх нь сайн сургалтын үр дүн гэж зарим эрдэмтэд үзжээ.

Багшийн 12 үүрэг:

1. Мэдээлэл түгээгч
 - a. Сайн лектор байх
 - b. Клиникийн болон дадлагын багш

2. Үлгэр дууриал үзүүлэгч

- a. Ажил дээрээ үлгэрлэх
- b. Багшлах үлгэр дууриалал

3. Туслагч, чиглүүлэгч

- a. Суралцахад нь туслагч
- b. Сургалтын удирдагч

4. Үнэлэгч

- a. Оюутныг үнэлэгч
- b. Сургалтын хөтөлбөрийг үнэлэгч

5. Төлөвлөгч

- a. Сургалтын хөтөлбөрийг төлөвлөгч
- b. Хичээл төлөвлөгч

6. Нөөц хөгжүүлэгч

- a. Нөөцийг бий болгогч
- b. Сургалтын удирдамж боловсруулагч

Анагаах ухааны боловсрол судлалын практикт багшийн үүргийг дээрх 6 үндсэн хүрээний үүргийн нийлбэр болон сургалтыг хөтлөн явуулах багшийн мэдлэг, ур чадвар, хандлага, заах арга зүйн ур чадвар, хувь хүний хөгжлийн нийлбэр үнэлгээгээр үнэлж дүгнэж байна.

Дүгнэлт

Анагаахын сургуульд багшлахуйн ур чадварын өнөөгийн түвшинг судалснаар багш нь оюутанд мэдлэг боловсрол, ур чадвар олгохоос гадна зааж буй хичээлээрээ дамжуулан мэргэжилдээ дур сонирхолтой, цогц чадамж бүхий анагаахын мэргэжилтэн болгоход чиглэгдэж байна.

Багш нь анагаахын сургалтыг чанартай явуулахын тулд тухайн шинжлэх ухааны зарчмыг сайн мэддэг, харилцаа хандлагыг сайн эзэмшсэн, аливаа асуудалд шийдвэр гаргах чадвартай, багаар хамтран ажиллагч, өөрийн мэдлэг, ур чадвар, мэргэжлийг тасралтгүй дээшлүүлэгч байх нь өнөө үед тавигдаж буй чухал асуудлын нэг болоод байна.

Ном зүй:

1. Отгонбаяр Д (2005) “Сургалтын чанарт нөлөөлж буй зарим хүчин зүйлс” магистрын зэрэг горилж бичсэн бүтээл, УБ
2. Отгонбаяр Д, Цэрэндагва Д, Сүмбэрзул Н (2007) Багш өөрийгөө үнэлэх асуудалд. Анагаах ухааны боловсрол сэтгүүл дугаар 1. 25-27
3. Сүмбэрзул Н, Оюунбилэг Ш (2001) Анагаах ухааны боловсрол. Улаанбаатар 61р хуудас
4. Туул Н (2004) Дээд боловсролын байгууллага дахь багшийн хөгжлийн орчны менежментийн асуудалд. Өнөөдөр сонин 2004.11.03 дугаар 257 (2301)
5. Цэрэндагва Д, Лхагвасүрэн Ц, Дүнгэрдорж Д (2007) Ази-Номхон Далайн бүсийн болон Монголын Анагаах ухааны боловсролын хөгжил. Анагаах ухааны боловсрол сэтгүүл. Дугаар 1. 13
6. Берт Криймерс, Леонидас Кириакайдс, панаиотис Антонио, (2013), Багшлахуйн чанарыг сайжруулахад багшийн хөгжил, Springer
7. Сургалтын бодлого зохицуулалттай холбоотой дүрэм журмын эмхэтгэл. (2019) АШУУИС.